



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/254

Булган сум

**Эрх шилжүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.5, 5 дугаар хавсралтын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан Сумын төвийн зам засвар (Булган сум), гэрэлтүүлгийн өргөтгөл, хүчин чадлыг нэмэгдүүлэх (Булган сум Зүүнтүрүү 4 дүгээр баг)-ийн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал)-д олгосугай.

2.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг ажлын даалгавар, батлагдсан зураг төсвийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр зохион байгуулж, гэрээ байгуулан хүлээн авахыг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал)-д үүрэг болгосугай.

3.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Баярцэнгэл)-д даалгасугай.

4.Хавсралтад тусгагдсан төсөл арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Сугар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

**6325010358**

Аймгийн Засаг даргын 20.25 оны  
04 дүгээр сарын 16-ны/ний өдрийн  
А.125.4... дугаар захирамжийн хавсралт

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Нийт төсөвт өртөг /мян.төг/	Тухайн онд санхүүжүүлэх төсөвт өртөг /мян.төг/	ХАА-нд мөрдөх журам	Тайлан мэдээ ирүүлэх хугацаа	Эрх шилжүүлсэн сумдын Засаг дарга, байгууллагын дарга
1	2	3	4	5	6	7
<b>Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ</b>						
1	Сумын төвийн зам засвар (Булган сум)	200,000.00	200,000.00	НТШ	Сар бүрийн 25-ны өдөр	Булган сумын Засаг дарга Д.Бямбажаргал
<b>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ</b>						
1	Гэрэлтүүлгийн өргөтгөл, хүчин чадлыг нэмэгдүүлэх (Булган сум Зүүнтүрүү 4-р баг)	120,000.00	120,000.00	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Булган сумын Засаг дарга Д.Бямбажаргал
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>320,000.0</b>	<b>320,000.0</b>			